

The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ

| ЗОРИГЖУУЛНА

| МЭДЭЛЖҮҮЛНЭ

Баасан, 2020.01.10, №01 (130)

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ, БИЕ ДААСАН,
УЛС ТӨРИЙН НАМААС ХАРААТ БУС, ДОЛОО ХОНОГ ТУТМЫН ГЛОБАЛ СОНИН

www.jargaldefacto.com

WEEKLY



ДеФакто **НИЙТЛЭЛ**
№510

Д.Жаргалсайхан
Эдийн засагч, нийтлэлч

ХАНШНЫ АЛДАГДЛЫГ ЯАГААР ЗӨВХӨН ЗЭЭЛДЭГЧ ХАРИУЦАХ ЁСТОЙ ГЭЖ?



НИЙТЛЭЛ

Г.Жавзмаа
Сэтгүүлч

ИРГЭД ТАТВАРТАА Эзэн болмоор байна

IV НҮҮРТ


ДеФакто **ТОЙМ**

➤ ТЭТГЭВРИЙН ЗЭЭЛ
ТЭГЛЭХ НЬ САНХҮҮГИЙН
САХИЛГАГҮЙ ПОПУЛИЗМ

➤ ХӨДӨЛМӨРИЙН
ХӨЛСНИЙ ДООД
ХЭМЖЭЭ НЭМЭГДСЭН
НЬ АЖИЛ ЭРХЛЭЛТИЙГ
БУУРУУЛАХ УУ?

VII НҮҮРТ

ХАНШНЫ АЛДАГДЛЫГ ЯАГААР ЗӨВХӨН ЗЭЭЛДЭГЧ ХАРИУЦАХ ЁСТОЙ ГЭЖ?



Энэ асуултыг монголын аж ахуйн нэгжүүд улам их тавих боллоо. Монголын арилжааны банкууд зээлдэгч компани нь бүтээгдэхүүн, үйлчилгээгээ төгрөгөөр борлуулдгийг мэдсээр байж, гадаад валютын зээлийг хэмжээ хязгааргүй “шахсаар” байна. Хүү нь эрэмбээр бага, олдоц илүү болохоор компаниуд ч “хууртагдан” гадаад валютын зээл авсаар, ялангуяа том төсөл хэрэгжүүлэгч компаниуд хоёр гурван жилийн дараа зээлийн дарамтанд орж байна. Зээл авсан үеийн ханшаар бол зээлээ хүүтэй нь бараг хэд дахин өсгөж төлсөн ч зарим зээлдэгчид дампуурч, бизнесээ алдах эрсдэлд орсоор байна.

Ийнхүү гадаад валютын зээлийн ханшны зөрөөний алдагдал монголын хувийн секторт бодит аюул дагуулаад байна. Ханшны уналт өөрөөс нь хамаараагүй учир зарим бизнес эрхлэгчид Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаар (МҮХАҮТ) дамжуулан арилжааны банкуудад хандаж гадаад валютын зээлийн нөхцлөө өөрчлөх уриалга хүртэл хүргүүлэв. Харин банкууд түүнийг нь хүлээж авсангүй.



The Defacto Gazette

НЭГ УЛИРЛЫН ҮНЭ
30.000₮

МОНГОЛ ШУУДАН
7007-8916

БОДИТ БАЙДАЛ

- ▶ Монголбанкны тоо баримтаас харахад 2018 оны эцэст валютын зээл банкуудын нийт зээлийн гуравны нэгийг эзлэж байсан бол, хугацаа хэтэрсэн зээлийн бараг тал нь, чанаргүй зээлийн дөрөвний нэг нь валютын зээл байсан нь анхаарал татаж байна. 2019 оны туршид компаниуд зарим нь барьцаа хөрөнгөө хураалгаж, зарим нь банктай тохиролцон зээлээ шинэ ханшаар төгрөгт хөрвүүлж, валютын зээлээ бууруулж байгаа ч, одоогоор нийт зээлийн тавны нэг, хугацаа хэтэрсэн зээлийн 37 хувь, чанаргүй зээлийн 23 хувь нь гадаад валютынх хэвээр байсаар байна. Валютын зээл өндөр эрсдэл дагуулсаар...


Гадаад валютын зээлийн нийт зээлд эзлэх хувь	2018.12.31	2019.11.30
Хэвийн зээл	32.56	22.03
Хугацаа хэтэрсэн зээл	45.30	37.14
Чанаргүй зээл	23.92	22.82

Эх сурвалж: Монголбанк ([Дэлгэрэнгүй](#))

Урт хугацааны, бага хүүтэй хөрөнгийн эх үүсвэр олж чадах эсэхээс монголын бизнесүүдийн амжилт бараг бүрэн хамаарч, улмаар ихэнх салбарын өрсөлдөөний гол хүчин зүйл болжээ. Тийм ч учраас экспортлогч биш компаниуд хүртэл хугацаа, нөхцлөөс нь болоод валютын зээл авсаар байна. Төгрөгийн зээл ховор буйн гол шалтгаан нь дотоодын хадгаламж харьцангуй багатай холбоотой.

Компаниуд валютын зээлийн алдагдлыг зөвхөн аж ахуйн нэгж дангаараа үүрэх нь шударга бус гэж үзэж байна. Учир нь валютын ханшны эрсдэл бол макро эдийн засгийн асуудал буюу төр засгийн бодлогын үр дагавар. Долларын ханш сүүлийн арван жилд хэрхэн өсч ирснийг эндээс харж болно.

2009-2018 оны хооронд АНУ-ын долларын ханш ба МУ-д орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын урсгал



Гадаадын шууд хөрөнгө оруулалт ([Дэлгэрэнгүй](#))

Эндээс яагаад аж ахуйн нэгжүүд доллараар авсан зээлээсээ болж хүнд байдалд орсныг бас ойлгож болно. МҮХАҮТ-аас гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл, хүнд нөхцөл байдлыг баталсан гэрчилгээ гаргадаг. 2017-2019 онд энэ гэрчилгээг 143 иргэн, аж ахуйн нэгжид олгосны тал нь валютын ханшийн өсөлттэй холбоотойгоор гэрээний үүргээ биелүүлэх боломжгүй болжээ.



- ▶ Компаниуд санхүүжилтээ гадаад валютын зээлээр аваад, харин борлуулалтаа дотоодын валютаар хийж буй тохиолдолд ханшны уналт зээлийн төлбөрийн эрсдлийг бий болгодог. Тухайн улсын дотоодын мөнгө нь 10 хувиар үнэгүйдэхэд, гадаад валютын зээлтэй компаниуд, дотоод валютын зээл авагчтай харьцуулахад зээлээ хугацаандаа төлөхгүй байх эрсдэл бараг 70 хувиар нэмэгддэг ажээ (*Schmidt-Eisenlohr, 2017*).

Энэ эрсдэл зөвхөн компанийн биш, цаашлаад банкны өөрийнх нь эрсдэл болон хувирч, улмаар улс орны эдийн засагт бүхэлд нь нөлөөлдөг. 2010 оноос хойш хөгжиж буй орнуудын хувийн секторын валютын зээлийн алдагдал өндөр хурдтай өссөөр байна. Экспортын чиглэлийн бизнесээс гадна экспортын бус бизнесүүд хүртэл гадаад валютын зээл авах болсонтой холбоотой ажээ. (Chui et al, 2016).

ГАРЦ

Валютын зээлийн ханшны эрсдэл нь тухайн улсын дотоодын ханш тогтвортой эсэхээс илүүтэй хамаардаг. Арван жилийн өмнө Монголын төгрөг, Солонгосын вон хоёр нэг нэгийн харьцаатай байсан бол өнөөдөр төгрөг хоёр дахин суларчээ. Солонгосын эдийн засаг эргэлдэж буй гадаад, дотоодын валютын харьцаа тогтвортой байна гэсэн үг.

Монголд болохоор гаднаас орж ирж буй валют багасаад, дотоод мөнгөний хэмжээ нь өсөөд байгаатай холбоотой. Тухайн орон валютын орлогоо нэмэх эхний хоёр сонголт бол: экспортоо өсгөх, мөн гадаадын хөрөнгө оруулалт ихээр татах явдал. Гадаадаас зээл авч болох ч, тэр зээл нь экспортын орлогыг өсгөж чадахгүй бол төгрөгийн ханшийг сулруулдаг. Үүнийг монголын жишээ маш тодорхой харуулдаг. 2012 оны 12-р сард Засгийн газар түүхэндээ анх удаа гадаадад бонд (Чингис бонд) гаргасан ч, тэр хэмжээгээрээ эдийн засгаа төрөлжүүлж, экспортоо өсгөж чадаагүй учир 1350 төгрөг байсан нэг доллар, долоон жилийн дараа 2700 төгрөг болсон байна. Түүнээс хойш эдийн засаг сайжирсангүй, өрийг өрөөр дарж ирсэн учраас Засгийн газар дампуурахын даваан дээр ОУВС-аас тодорхой нөхцөлтэй тусламж авсан. Нэг нөхцөл нь банкны салбарын үйл ажиллагаагаа шинэчлэх ёстой байсан ч, хийж чадахгүй гурван жил болж байна.

2008 оны санхүүгийн хямралаар манайтай төстэй байдал үүссэн Зүүн Европын орнууд Европын холбооны

шахалтаар санхүүгийн зохицуулалтаа чангатгаж, валютын зээлийн шаардлагаа өндөрсгөсөн учир эрсдлээ багасгаад байна.

Монголбанк ч, Хөгжлийн банк ч гэсэн валютын зээлд тавих шаардлагаа чангалж, тодорхой бодлого хэрэгжүүлэх цаг болжээ. Үүнд, магадгүй экспортын бус бизнесүүдэд валютын зээл олгохгүй байх, олгосон ч ханшны зөрөөний эрсдлийн хэджингийн (hedging) үйлчилгээ бий болгох, төгрөгийн зээлийн хүүг бууруулах, хугацааг уртасгахад анхаарах хэрэгтэй байна.

Манайх шиг хөгжиж буй орнуудын хувьд валютын ханшаа тогтвортой барихын тулд гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхээс л өөр сонголт байхгүй. Гэтэл Монголбанкны төлбөрийн тэнцлийн статистикаас харвал 2014 оноос хойш гадаадын шууд хөрөнгө оруулалтын урсгал өнөөдрийг хүртэл зогсонги болоод байна. Монгол улсад гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг татахын тулд салбар бүрт шударга өрсөлдөөнийг бүрдүүлж, төрийн өмчит компаниудыг хувьцаат компани болгож, арилжааны банкуудын улс төрийн нөлөөг багасгах, улмаар ханшны зөрөөний алдагдлыг зээлдэгч, зээл олгогч хоёр ядаж хувааж хариуцахаар зохицуулах шаардлагатай байна.

2020.01.09

“ЭРХ ЧӨЛӨӨ”
ГУРВАЛ НОМ

Интерном номын
дэлгүүрийн бүх салбаруудаар
худалдаалагдаж байна.

+(976) 9410 9342



Г.Жавзмаа
Сэтгүүлч

ИРГЭД ТАТВАРТАА


Эзэн болмоор байна

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН ГЭЖ ЮУ ВЭ?


Иргэдийн оролцоогүйгээр асуудлыг нь шийдэх гэсэн коммунист арга ямар үр дүнд хүргэж байгааг Улаанбаатар хотоор тэр дундаа гэр хороолол дундуур хэсэг явахад л мэдэрнэ. Иргэн А-ийн амьдарч байгаа хороонд улсын төсвөөс хуваарилсан мөнгө нь хүрээгүй учраас гэрэлтүүлэг байхгүй тас харанхуй гудмаар хэний нохойд хазуулж, хэнд дээрэмдүүлчих бол гэсэн айдастай алхах энүүхэнд. Тэгвэл төсвөөс хуваарилсан мөнгө хүрэлцээгүй ч заавал хийгдэх ёстой, иргэдийн өдөр тутмын амьдралд чухал нөлөөтэй ажлыг хаанаас санхүүжүүлж хэн хийх үүрэгтэй юм бэ? Энэ бол иргэдийн хамгийн сайн мэдэж байх ёстой сан буюу Орон нутгийн хөгжлийн сан (ОНХС). Учир нь энэ санд хуримтлагдаж байгаа хөрөнгөөр ямар ажил хийхийг иргэдээс санал авч шийддэг юм. Өөрөөр хэлбэл нутгийн

иргэдийн оролцоотойгоор тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг шийдвэрлэх зорилготой ба энэ нь 2013 онд хэрэгжиж эхэлсэн Төсвийн тухай шинэ хуульд тусгалаа олсон. Энэ сан орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэдэд тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцлийг бүрдүүлнэ гэсэн том зорилготой.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан (ОНХС)-ийн эх үүсвэрийг дотоодын НӨАТ, газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлого, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл, ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл зэрэг төсвийн орлогын тодорхой хувиар тооцож бүрдүүлдэг. Доорх зургаас бүрдүүлэлтийн хувийг харж болно.



ОНХНС-д 2013-2019 онд нийт 1 их наяд 8 тэрбум төгрөгийн хөрөнгө хуваарилжээ. Харин 2020 онд 188 тэрбум төгрөг хуваарилсан байна.



Товчхондоо иргэн таны татварт төлсөн хөрөнгөөс буцаагаад таны амьдрах орчныг сайжруулах зорилгоор орон нутагт нь дахин хуваарилж байгаа хөрөнгийг хэлж байгаа юм.


ЭНЭ САНГИЙН ХӨРӨНГӨӨР ЮУ ХИЙХ БОЛОМЖТОЙ ВЭ?

ОНХС-ийн хөрөнгийг орон нутгийн дэд бүтцийг сайжруулах, нийтийн эзэмшлийн талбайн тохижилт, гэрэлтүүлгийг сайжруулах, бэлчээрийг хамгаалах, инженерийн хийцтэй худаг гаргах, булаг, шандыг хамгаалах зэрэг ажлыг санхүүжүүлэхэд зарцуулах ёстой. Харин улс төрийн нам, төрийн бус байгууллагын зарлага; Үндэсний их баяр наадмаас бусад баяр, наадам, ойн арга хэмжээ, шашны зан үйл болон ёслолын зардал; Нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа; Орон нутгийн иргэдийн санал аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээнд энэ сангийн хөрөнгийг зарцуулахыг хориглодог.

2013 оноос Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөлд иргэдийн саналыг тухайн жилийн нэгдүгээр улиралд багтаан цаасан хэлбэрээр авдаг байсан бол 2018 оноос Улаанбаатар хотод цахим хэлбэрээр авах боломж бүрджээ. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын санаачилгаар бусад албаныхантай хамтран ухаалаг утасны SmartUB аппликейшнийг хөгжүүлж 2018 онд туршилтын цахим санал асуулгыг 9 дүүргийн 19 хороонд хэрэгжүүлж, нийт 13,000 иргэдийн санал авсан байна. Үүний дараа 2019 оны 4-р сарын 8-аас 5-р сарын 8-ны хооронд нэг сарын хугацаанд 2020 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлын талаарх иргэдийн саналыг мөн SmartUB аппликейшнээр авчээ. Энэ цахим санал асуулгад 6 дүүргийн 42 хорооны иргэд хамрагдсан бөгөөд санал асуулгад оролцох ёстой байсан 176,000 иргэнээс 43 хувь буюу 76,330 иргэн SmartUB аппликейшныг ашиглан, цахимаар саналаа өгсөн байна.

ДҮҮРЭГ	ЦАХИМААР САНАЛ АСУУЛГАД ОРОЛЦСОН ИРГЭДИЙН ТОО	ХҮЧИНГҮЙ САНАЛ	ЦАХИМ САНАЛ	ДҮҮРГҮҮДИЙН ИРГЭДИЙН ОРОЛЦОО
Багануур	7977	0	7971	40.92%
Багахангай	1525	1	1523	99.87%
Баянзүрх	6909	11	6176	20.72%
Налайх	11790	24	11571	48.18%
Хан-Уул	6298	5	6246	18.56%
Чингэлтэй	41707	74	41414	61.06%
НИЙТ	76330	115	74911	43.3 %

Уг нь ОНХС-ийн цахим санал асуулгад жил бүр 18-аас дээш насны иргэд оролцох боломжтой. Гэтэл 2019 оны санал асуулгад SmartUB аппликейшнийг ашиглан саналаа өгсөн иргэдийн 13 хувь нь л 18-25 насныхан байв.



Харин одоо 2021 онд хэрэгжүүлэх ажлын санал асуулгад Улаанбаатар хотын 9 дүүргийн нийт 173 хорооны 18-аас дээш насны бүх иргэдийг хамруулахаар төлөвлөн, бэлтгэл ажлыг хийж байна.

ЭНЭ САНГИЙН ХӨРӨНГӨ ЮУНД ЗАРЦУУЛАГДАХЫГ ХЭН ШИЙДДЭГ ВЭ?

2018 оноос иргэд өөрсдийн амьдрах таатай орчноо бүрдүүлэхийн тулд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх аливаа ажилд саналаа өгөх, бүтээлчээр оролцох боломж нь эрх зүйн хувьд нээлттэй болсон. Угаас иргэд л оршин суугаа орон нутгийнхаа нөхцөл байдлыг хэнээс ч илүү мэдэх бөгөөд тэд өөрсдийн нийтлэг ашиг сонирхол, хэрэгцээг хамгийн сайн төлөөлж чадна. 2019 онд санал асуулгад хамрагдсан нийт 76 мянган иргэдээс 2020 онд амьдарч буй хороондоо камержуулалтын ажил хийлгэх саналыг хамгийн их өгсөн буюу 21 хувь байв. Харин 15 хувь нь гэр хорооллын дахин төлөвлөлт, 13 хувь нь гэрэлтүүлэг, 11 хувь нь хүүхдийн тоглоомын талбай болон биеийн тамирын талбай, 9 хувь нь явган хүний зам гүүртэй болох гэдэгт саналаа өгчээ. Гэтэл 4 хувь нь л нийтийн тээврийн хүртээмжийг сайжруулах ажилд саналаа өгсөн нь хамгийн бага санал авсан ажил байв.

ОНХС-ийн хөрөнгөөр ГЭР ХОРООЛЛЫН хөгжилд шаардлагатай хөрөнгө оруулалтын талаар иргэдийн өгсөн санал



ОНХС-ийн хөрөнгөөр ОРОН СУУЦНЫ ХОРООЛЛЫН хөгжилд шаардлагатай хөрөнгө оруулалтын талаар иргэдийн өгсөн санал



Иргэний нийгэм өндөр хөгжсөн оронд хүмүүс нь төр засгийн шийдвэр гаргахад идэвхтэй оролцдог, хэрэгжилтийг нь хянадаг, хариуцлага тооцдог. Харин манайд иргэний нийгэм идэвхтэй биш байгаа учир улс төрчдөд төрөөр дамжуулан бизнес хийх, хувьдаа ашиг олох, нийтийн хөрөнгийг зувчуулан баяжих боломж олдсоор байгаа. Тиймээс ОНХС бол иргэдийнх нь мэдэлд бүрэн өгч байгаа хөрөнгө гэдгийг санаж 2020 оны санал асуулгад SmartUB аппликейшнийг ашиглан саналаа өгөөрэй. Иргэдийн яахаа шийдсэн бүтээлч оролцоог төр засаг санхүүгээр дэмжвэл бодит өөрчлөлт гарна гэдэгт итгэлтэй байна.



ДеФакто **тойм**

Ням гараг бүр VTV телевизээр 21 цагт гардаг Дефакто тоймын эмхэтгэл:
2020.01.05-ны дугаар

Долоо хоног бүрийн тойм, <http://jargaldefacto.com/category/12>

ТЭТГЭВРИЙН ЗЭЭЛ ТЭГЛЭХ НЬ САНХҮҮГИЙН САХИЛГАГҮЙ ПОПУЛИЗМ

МУ-ын Ерөнхийлөгч он солигдох мөчид олон нийтэд хандаж хэлсэн үгэндээ “Ахмад буурлуудаа өрийн дарамтнаас салгах зорилгоор алдагдсан байсан Салхитын мөнгөний ордоо эдийн засгийн эргэлтэд оруулах замаар тэтгэврийн зээлийг нэг удаа тэглэх тухай Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлийн (ҮАБЗ) гишүүд санал нэгдэн шийдвэр гаргасныг ахмадууд та бүхэндээ дуулгаж байна” гэсэн ноцтой шийдвэрийг танилцуулсан. Гэхдээ энэ шийдвэрийг УИХ хэлэлцэж эцсийн шийдвэрийг гаргана.

Энэ асуудлаар бусад албаныхан болон иргэд нийгмийн сүлжээгээр хэлэлцүүлэг өрнүүлсээр байна. ЗГХЭГ-ын дарга Л.Оюун-Эрдэнэ: “Салхитын мөнгөний ордын ТЭЗҮ гарсан. Улсад хоёр их наяд төгрөгийн хөрөнгө хуримтлуулах боломжтой, таван жилийн хугацаатай ТЭЗҮ гарсан байгаа. Үүний үр өгөөжийг иргэдэд шууд хүртээх жишиг тогтоох ерөнхий философи үйлчилж байна гэж би хувьдаа ойлгосон” гэв.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг: “Ерөнхий сайдын захирамжийн дагуу Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас ажлын хэсэг байгуулан төсөл боловсруулж УИХ-д танилцуулах шаардлагатай боллоо. Одоогоор 231 мянган ахмад 776 тэрбум төгрөгийн тэтгэврийн зээлтэй байна. Ахмадууд төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үеэс л ажиллаж, улс эх оронд залуу насаа зориулсан хүмүүс учраас төрдөө үнэлэгдэн зээлээ тэглүүлэх нь зөв” гэв.

Банкуудад тэр зээлийг нь нийт Монголчууд татвараараа төлж байгаа. Төлөх хүмүүсээс нь асуухгүй, өөрсдөө төлсөн мэт харагдах улс төрөө гэж!

Улс төрийн хэт популист бодлого нь эдийн засгийнхаа бодит хүч чадлаас хэт томдсон нийгмийн хамгаалал, халамжийг бий болгож, улмаар төсвийн алдагдлыг хөөрөгдөн, төрийг зээлийн өрөнд суулгачихсан. Зөвхөн бондуудын өр гэхэд 2021, 2022, 2023, 2024 онд нийт 2.9 тэрбум долларын өр төлнө.



2021 онд Чингис бондын 1 тэрбум доллар төлнө. Дараа нь Хуралдай бонд 600 сая доллар, Гэрэгэ бонд 800 сая доллар, Мазаалай бондын 600 сая доллар төлнө.

Бүр үнэхээр тэтгэврийн зээлийг тэглэлээ гэхэд мөнгө үнэгүйднэ, инфляци нэмэгдэнэ, төгрөгийн ханш унана гэдэг хүлээлттэй байх ёстой. Монгол улс тооцоогүй валютын өр ихээр тавьж одоо болтол үүнээсээ гараагүй байгаа. Өрийг завшсан этгээдүүд ямар ч ял шийтгэл аваагүй. Засгийн газар одоо хүртэл гадаад өрөө өөр өр дахин тавьж дарж ирсэн. Монгол улсын ядуурлын түвшин 28.4 хувь буюу хүн амын гуравны нэг нь ядуу гэсэн ангилалд байгааг сануулах ч илүү биз. Шударга ёс талаасаа ярьвал зээл аваагүй 100 мянга гаруй ахмад байгаа. Тэднийг яана гэж?

Төлөх ёстой зээлээ хүн өөрөө л төлөх ёстой, үгүй бол зээл гэдэг зүйлийн агуулга алга болчихно шүү дээ. Хорвоо дээр авсан бүх зээлийг нь өөр хүн төлдөг бол зээл авах аргачлал ч өөр болно шүү дээ. Эдийн засгийн бус аргаар сонгууль худалдан авах гэсэн улс төрчдийн томоохон оролдлого, алсын хараагүй явдал.


МУ-ын ҮАБЗ-ийн хууль гэж байгаа. Энэ хуульд зөвлөлийн чиг үүргийг тодорхойлсон байдаг. Түүний 2-р заалтад “Монгол Улсын үндэсний баялгийг зүй зохистой ашиглах, үндэсний технологийг хамгаалж орчин үеийн ололтоор баяжуулан хөгжүүлэх, дэлхийн

аж ахуйн хэлхээ холбоонд идэвхтэй, уян хатан оролцох зэргээр эдийн засгаа дотоод нөөц бололцоондоо тулгуурлан бие даан хөгжих чадавхийг нэмэгдүүлнэ” гэж заасан. Мөн 7-р заалтад “Монгол Улсын үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдлын ашиг сонирхлын үүднээс олон улсын нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан, технологи, цэрэг, улс төрийн байдалд дүн шинжилгээ хийж, шаардлагатай арга хэмжээг тодорхойлно” гэж заасан байдаг. ҮАБЗ нэртэй Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Их хурлын дарга гэсэн 3 хүн дээрх хоёр үүргийнхээ эсрэг шийдвэр гаргасан гэсэн үг.

ХӨДӨЛМӨРИЙН ХӨЛСНИЙ ДООД ХЭМЖЭЭ НЭМЭГДСЭН НЬ АЖИЛ ЭРХЛЭЛТИЙГ БУУРУУЛАХ УУ?

Өнгөрсөн онуудад УИХ-аас батлагдан гарсан хууль тогтоомжууд 2020 оны 1-р сараас хэрэгжиж эхэллээ. Үүний нэг нь 2018 оны 5-р сард хөдөлмөр, нийгмийн гурван талт хэлэлцээрийн үр дүнд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 420 мянган төгрөг боллоо. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 2019 оны байдлаар 320 мянган төгрөг байсан.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ гэдэг нь хүнийг ажилд авахдаа наад зах нь өгөх цалин ба монголд энэ хэмжээг 2 жил тутамд нэмнэ гэсэн шийдвэр байдаг. Улсын хэмжээнд 1,1 сая хүн ажил эрхэлж байгаа бөгөөд үүний 8 хувь буюу 80 мянган хүн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжиж байна. Энэ хэмжээг тогтоосноор эдийн засагт юу болох талаар судалгаанууд байдаг. Тухайн оронд ажиллах хүчний нийлүүлэлт, хэрэгцээ 2 нь нийлж огтлолцох цэгийг цалин гэж бодвол энэ цалин нэмэгдмэгц нөгөө огтлолцол нь өөр болоогүй учраас хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлснээр ажилтай хүний тоо багасдаг хамаарал байна. Мөн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлснээр залуучууд ажлын дадлага бий болгохгүйгээр цалин авах боломж



бүрдмэгц өрсөлдөх чадвар нь бага байдаг юм байна. Ажил олгогч мэдээж хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдмэгц цөөн хүн ажилд авахыг боддог. Ийм маягаар эдийн засагт оруулж байгаа энэ бодлого нь хөдөлмөрийн бүтээмжтэй холбогдолгүй, захиргааны аргаар хийгдэж байгаа учраас бүгдээрээ хавтгайрч бага зэрэг цалин нэмэгдэж байгаа ч ажилчдын тоо нь багасаж байгаа. Эдийн засгийн хамгийн зөвөөр цалинг өсгөх арга бол дандаа л өрсөлдөөн байдаг.

Дефакто тоймын гол агуулгыг хураангуйлан бэлтгэв
Тоймын бүрэн эхийг jargaldefacto.com вебсайтаас үзэх боломжтой.



Та “Дефакто Газет” цахим сонинг тогтмол хүлээн авахыг хүсвэл
www.jargaldefacto.com болон www.defacto.mn вебсайтад өөрийн имейлээ бүртгүүлнэ

Ерөнхий эрхлэгч:
Дамбадаржаагийн Жаргалсайхан
Ерөнхий Редактор:
Ганбаатарын Жавзмаа

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАГ
Отгонсүрэнгийн Билгүүн
Адъяагийн Тунгалаг

ХОЛБОО БАРИХ
✉ editor1@jargaldefacto.com
☎ +976 94109342
🌐 www.defacto.mn